

UCS 1106B:2025

# НИЙГМИЙН ДЭД БҮТЭЦ




Ерөнхий боловсролын сургуулийн барилгын  
гадна засалд тавих шаардлага



# НИЙГМИЙН ДЭД БҮТЭЦ

Ерөнхий боловсролын сургуулийн барилгын гадна  
засалд тавигдах шаардлага

*Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2025 оны 25/07-р тогтоолоор батлав.*



## ГАРЧИГ

|                                                              |    |
|--------------------------------------------------------------|----|
| 1. Хамрах хүрээ.....                                         | 4  |
| 2. Норматив эшлэл .....                                      | 4  |
| 3. Нэр томъёоны тодорхойлолт .....                           | 4  |
| 4. Төлөвлөлтийн ерөнхий шаардлага.....                       | 5  |
| 5. Гадна фасадад тавигдах ерөнхий шаардлага .....            | 5  |
| 6. Дулаалгын материалд тавигдах ерөнхий шаардлага .....      | 8  |
| 7. Цонх .....                                                | 8  |
| 8. Хаалга .....                                              | 10 |
| 9. Дээвэр.....                                               | 11 |
| 10. Сургуулийн барилгын өнгөний ерөнхий шаардлага .....      | 11 |
| 11. Сургуулийн орчны аюулгүй байдлын ерөнхий шаардлага ..... | 12 |
| 12. Шалгах хуудас .....                                      | 13 |
| Ашигласан материалын жагсаалт.....                           | 19 |

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

|                                                                        |    |
|------------------------------------------------------------------------|----|
| Зураг 1. Чулуун хавтан фасадын хэсэглэл .....                          | 6  |
| Зураг 2. Чулуун будгаар шүршсэн фасадын хэсэглэл .....                 | 6  |
| Зураг 3. Металл /хөнгөн цагаан/ фасадын хэсэглэл .....                 | 7  |
| Зураг 4. Сургуулийн барилгын гадна гэрэлтүүлгийн харагдах байдал ..... | 7  |
| Зураг 5. Гадна цонхны хэсэглэл /дээд/.....                             | 9  |
| Зураг 6. Гадна цонхны хэсэглэл /доод/ .....                            | 9  |
| Зураг 7. Барилгын орц, гадна довжоо, налуу замын стандарт .....        | 10 |
| Зураг 8. Дээврийн хур тунадасны ус зайлуулах сифонон систем .....      | 11 |

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

|                                                     |    |
|-----------------------------------------------------|----|
| Хүснэгт 1. Барилгын гадна фасадын өнгө (жишээ)..... | 12 |
| Хүснэгт 2. Шалгуур үзүүлэлт.....                    | 13 |



НИЙСЛЭЛИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2025 оны 01 сарын 24 өдөр

Дугаар 45/07

Улаанбаатар хот

Нийгмийн дэд бүтцэд хамаарах  
хотын стандартыг батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.15 дахь заалт, 35 дугаар зүйлийн 35.1.13 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Монгол улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалт, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 10<sup>1</sup> дүгээр зүйлийн 10<sup>1</sup>.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн иргэдийн эрүүл аюулгүй, амьдрах эрхийг хангахад чиглэсэн “Нийгмийн дэд бүтэц” бүлэгт хамаарах дор дурдсан хотын стандартуудыг хавсралтаар баталсугай.

1.1. UCS1106B:2025 “Ерөнхий боловсролын сургуулийн барилгын гадна засалд тавигдах шаардлага” хотын стандартыг нэгдүгээр хавсралтаар;

1.2. UCS1107B:2025 “Ерөнхий боловсролын сургуулийн барилгын дотор засалд тавигдах шаардлага” хотын стандартыг хоёрдугаар хавсралтаар;

1.3. UCS1108B:2025 “Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын барилгын гадна засалд тавигдах шаардлага” хотын стандартыг гуравдугаар хавсралтаар;

1.4. UCS1109B:2025 “Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын барилгын дотор засалд тавигдах шаардлага” хотын стандартыг дөрөвдүгээр хавсралтаар;

1.5. UCS1101C:2025 “Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны жишиг зураг төсөл” хотын стандартыг тавдугаар хавсралтаар;

2. Батлагдсан хотын стандартыг олон нийтэд сурталчлан, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолыг 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдсүгэй.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бүсчилсэн хөгжлийн хороо (Л.Ариунтуяа)-д даалгасугай.

ДАРГА

А.БАЯР

17.01.2025

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн  
дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт



## НИЙГМИЙН ДЭД БҮТЭЦ

UCS 1106B:2025

### “ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН БАРИЛГЫН ГАДНА ЗАСАЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА” ХОТЫН СТАНДАРТ

#### 1. ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү стандарт нь Ерөнхий боловсролын сургуулийн барилгын гадна заслын төлөвлөлтөд тавигдах ерөнхий шаардлагыг тодорхойлох бөгөөд энэ төрлийн үйл ажиллагаа явуулж буй иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагууд дагаж мөрдөнө.

#### 2. НОРМАТИВ ЭШЛЭЛ

Энэхүү стандарт нь эш татсан дараах барилгын норм ба дүрэм, стандартын шаардлагыг бүрэн хангах бөгөөд өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлийн эх материалыг үндэслэл болгоно.

- БНБД 31-10-05 Заслын ажил;
- БНБД 31-25-22 Ерөнхий боловсролын сургуулийн барилгын төлөвлөлт;
- БНБД 31-03-03 Олон нийт иргэний барилга;
- БНБД 40-05-16 Барилга доторх ус хангамж, ариутгах татуурга;
- БНБД 31-23-22 Барилга, байгууламжид хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүртээмжийг төлөвлөх;
- MNS 6782:2019 Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал, ерөнхий шаардлага.

#### 3. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

**Ерөнхий боловсрол** – гэж бага, суурь, бүрэн дунд боловсролын түвшин бүхий нийт 12 жилийн хугацаанд эзэмших боловсролыг;

**Суралцагч** – гэж боловсролын сургалтын байгууллагад албан ёсоор суралцаж байгаа хүнийг;

**Сургалтын орчин** – гэж сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах, эрх бүхий байгууллагаас баталсан стандарт, техникийн зохицуулалтад нийцсэн материаллаг болон сэтгэл зүйн нөхцөл, сурах, сургах харилцааг;

**Ялгаатай хэрэгцээ** – гэж хүний боловсрол эзэмшихтэй холбоотой хөгжлийн бэрхшээл, онцгой авьяас, хэл, соёл, жендер, нийгэм, эдийн засаг, байршлын ялгаанаас үүдэлтэй хэрэгцээг;

**Барилгын материал** – гэж стандарт, эрүүл ахуй, экологийн шаардлагыг хангасан барилга байгууламжид хэрэглэгдэх эрдэс, түүхий эд, материал, бүтээц, бүтээгдэхүүн, эдлэхүүнийг;

**Азбест** – гэж байгаль дээр тархсан шөрмөсөн чулуулаг эрдсүүдийг;

**Конденсаци** – гэж ямарваа нэгэн бодис хийн төлөвөөс шингэн төлөвт шилжихийг;

**Электролит** – гэж уусмалд байхдаа ион буюу эерэг болон сөрөг цэнэгтэй хэсгүүдэд задарч, цахилгааны гүйдлийг дамжуулахад оролцдог бодисыг;

**Цонхны нээлхий** – гэж барилгын хана, шал, таазанд гаргасан цонх суурилуулах зориулалттай нүхийг;


**Фасад** – гэж барилга, байгууламжийг өнгө төрхийг илэрхийлэх мөн гадна ханыг болон түүний бүрэлдэхүүн хэсгүүдийг байгалийн болон бусад хүчин нөлөөллөөс хамгаалах хийц.

#### 4. ТӨЛӨВЛӨЛТИЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА


- 4.1. Ерөнхий боловсролын сургуулийн барилгын гадна заслыг төлөвлөхдөө дараах зарчмыг баримтална. Үүнд:
  - 4.1.1. Сурах аюулгүй, эрүүл орчныг бүрдүүлнэ;
  - 4.1.2. Ашиглалтын үеийн засвар үйлчилгээ хийхэд хялбар байх;
  - 4.1.3. Ашиглалтын хугацааг тодорхойлсон байх;
  - 4.1.4. Азбест, хар тугалга зэрэг хүнд металл агуулаагүй, хорт уур, хий, эслэг ялгаруулахгүй, баталгаажсан аюулгүй материалыг ашиглах.
- 4.2. Ерөнхий боловсролын сургуулийн барилгын гадна заслын ажлыг “Заслын ажил” БНБД 31-10-05-ын дагуу гүйцэтгэнэ.
- 4.3. Сургуулийн барилгыг шинээр барих, шинэчлэхдээ хөгжлийн бэрхшээлтэй хүний хүртээмжтэй байдлыг хангасан байх ба БНБД 31-23-22-ын дагуу төлөвлөнө.
- 4.4. Сургуулийн гадна фасадын өнгийг орчин тойрны байгалийн өнгө төрх, барилгын загвар дизайн, хийцлэлд уялдуулсан байна.
- 4.5. Гадна фасадын материал нь 20 ба түүнээс дээш жил ашиглах боломжтой, удаан эдэлгээтэй байх нь зохистой.
- 4.6. Сургуулийн барилгын эзлэхүүн төлөвлөлт, бүтээцийн шийдэл нь галын аюулгүй байдлын шаардлагыг хангасан байна.
- 4.7. Сургуулийн барилгын гадна талыг цавуун будгаар будахыг хориглоно.

#### 5. ГАДНА ФАСАДАД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА


- 5.1. Сургуулийн барилгын гадна фасадыг дараах материалаар хийвэл зохимжтой. Үүнд:
  - Чулуу, чулуун хавтан: бат бөх, дулаан хадгалах чадвартай, гоёмсог харагдацтай;
  - Чулуун будаг: барилгын гадаргууг элэгдэл, зэврэлт, цаг агаарын нөлөөллөөс хамгаалдаг, арчилгаа багатай, бат бөх;
  - Металл /хөнгөн цагаан хавтан/: хөнгөн, суулгахад хялбар, галд тэсвэртэй, зэврэлт, муудахаас хамгаалагдсан, удаан эдэлгээтэй.



Зураг 1. Чулуун хавтан фасадын хэсэглэл (жишээ зураг)



Зураг 2. Чулуун будгаар шүршсэн фасадын хэсэглэл (жишээ зураг)



*Зураг 3. Металл /хөнгөн цагаан/ фасадын хэсэглэл (жишээ зураг)*

- 5.2. Сургуулийн гадна фасадын дулаалгын материалд хөөсөн полистрол хавтанг ашиглахыг хориглоно.
- 5.3. Гадна фасадын угсралтын ажлыг хүйтний улирал болон цаг агаарын тохиромжгүй нөхцөлд гүйцэтгэхийг хориглоно.
- 5.4. Сургуулийн барилгын нүүрэн талын фасад гэрэлтүүлэгтэй байвал зохимжтой.



*Зураг 4. Сургуулийн барилгын гадна гэрэлтүүлгийн харагдах байдал (жишээ зураг)*

- 5.5. Барилгын гадна фасадад ашиггүй догол, нарийн төвөгтэй хэлбэрээс зайлсхийж төлөвлөнө.
- 5.6. Хана нь ус чийгийн хамгаалалттай, уулзварууд нь битүүмжлэгдсэн байх ёстой.
- 5.7. Гадна фасадын материал нь удаан эдэлгээтэй байх бөгөөд дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
  - Байгаль орчинд ээлтэй;
  - Ус болон салхинаас хамгаалалттай;
  - Галд тэсвэртэй, галын тархалтыг хязгаарлахаар;
  - Байнгын цэвэрлэгээ, засвар үйлчилгээ шаарддаггүй;

- Засвар үйлчилгээ хийхэд хялбар, эвдэрсэн тохиолдолд амархан цэвэрлэж, солих боломжтой;
- Материалууд хоорондоо химийн болон электролитийн хувьд бие биедээ нийцдэг;
- Ус зайлуулах системтэй, конденсац үүсэх зэрэг бүх ус, чийгийг гадагшлуулдаг;
- Дулааны алдагдал багатай;
- Дуу чимээний тусгаарлалт сайтай;
- Температурын өөрчлөлт, салхи, засвар үйлчилгээ, цэвэрлэгээ зэрэгт тэсвэртэй;
- Замаг, хөгц, мөөгөнцөр үрждэггүй.

## **6. ДУЛААЛГЫН МАТЕРИАЛД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА**

6.1. Дулаалгын материал нь дараах ерөнхий шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй;
- Галд тэсвэртэй;
- Ашиглалтын хугацаа урт;
- Байгальд ээлтэй;
- Удаан эдэлгээтэй;
- Гажилтад тогтвортой;
- Чийг ус үл нэвтрүүлдэг байна.

6.2. MNS 6470:2014 Барилгын дулаан тусгаарлах ноосон материал. Техникийн шаардлага үндэсний стандартад нийцсэн дуу, дулаан тусгаарлагч материалаар дүүргэж, ам зөрүүлэн дулаална.

6.3. Дулаалгын материал нь 150мм-ийн зузаантай байна.

6.4. Гадна фасадад ашиглаж байгаа чулуун хөвөнгийн нягт нь хатуу хэсгээрээ  $120\text{кг/м}^3$ , зөөлөн хэсгээрээ  $75\text{кг/м}^3$ , EN 13501-1 стандарт болон галын А1 ангилалд багтсан байна.

6.5. Чулуун хөвөнгийн богино хугацаанд ус шингээх чанар нь  $0,3\text{кг/м}^3$ -аас хэтрэхгүй байна.

6.6. Дулаалгын чулуун хөвөнг зориулалтын уур, ус, чийг тусгаарлагчаар бүрсэн байх шаардлагатай.


6.7. Зэрэгцээ угсрагдсан чулуун хөвөн хавтангуудын зузааны зөрүү 2мм-ээс ихгүй байна.

6.8. Угсрагдсан чулуун хөвөн хоорондын зайг галд тэсвэртэй дүүргэгч материал ашиглан битүүмжилнэ.


## **7. ЦОНХ**

7.1. Цонх нь “UCS1501C Хаалга, цонхонд тавигдах ерөнхий шаардлага” стандартыг хангасан байна.

7.2. Цонхны гадаргуу нь байгалийн гэрлийг сайн тусгадаг материалаар хийгдсэн, дулаан тусгаарлагчтай, шил нь 3 давхар, эрчим хүчний хэмнэлттэй, LOW-E бүрэлттэй байна.



Зураг 5. Гадна цонхны хэсэглэл /дээд/ (жишээ зураг)




Зураг 6. Гадна цонхны хэсэглэл /доод/ (жишээ зураг)

- 7.3. Сургуулийн барилгын цонх нь томоор онгойлгохоос сэргийлсэн түгжээгээр тоноглогдсон байна.
- 7.4. Цонхны хүрээ нь бат бөх, урт настай, дулаан хадгалах чадвартай материалуудаар хийгдсэн байх. Жишээлбэл, PVC, хөнгөн цагаан, мод зэрэг материалууд тохиромжтой.
- 7.5. Аюулгүй байдлын үүднээс сургуулийн цонхонд нэмэлт хаалт тавих эсхүл хамгаалалтын тор суурилуулах нь зохимжтой.
- 7.6. Цонхны нээлхий дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
  - 7.6.1. Цонхны нээлхийг найдвартай хязгаарлах хэрэгслээр тоноглоно;
  - 7.6.2. Цонх нь аюулгүй байдлыг хангасан цоожтой байна;
  - 7.6.3. Цонх нь хүүхэд цонхоор авирч гарах (цонхоор унах) эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор суурилуулагдсан байна;
  - 7.6.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн хэрэглэх боломжийг хангасан байна.

## 8. ХААЛГА


- 8.1. Барилгын гол хаалга, гадна довжоо нь UCS 1101B:2022 хотын стандартад нийцсэн байна.
- 8.2. Сургуулийн хаалга нь гадагш онгойлттой, цаг уурын нөхцөлд тэсвэртэй, бат бөх материалаар хийгдсэн байна.
- 8.3. Сургуулийн гол орц болон хөдөлгөөний эрчим ихтэй гадна хаалгануудад хур тунадаснаас хамгаалах саравч төлөвлөнө.
- 8.4. Хаалганы өндөр газрын түвшнээс 3 гишгүүр (40 см-ээс бага)-ээс илүүгүй байна.
- 8.5. Хаалга нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүртээмжтэй байдлыг хангасан, налуу зам, гар бариултай байна. Хаалганы бариул нь барихад хялбар, бат бөх материалаар хийгдсэн байна. Бариулын зузаан нь 2-4 см, бариулын өндөр нь газраас 85-110 см байна.
- 8.6. Барилгад тэргэнцэртэй иргэн хэн нэгний тусламжгүйгээр нэвтрэх боломжийг хангаж шалны хоорондох уналтын зөрүү 4 см-ээс их бол налуу зам хийх ба зам нь 1х12 харьцаа бүхий налуутай байна. Барилгын орц, гадна довжоо, налуу замын стандарт зай хэмжээ, харагдах байдлыг Зураг 7-д үзүүлэв.



Зураг 7. Барилгын орц, гадна довжоо, налуу замын стандарт (жишээ зураг)

## 9. ДЭЭВЭР

- 9.1. Дээврийн ажлыг UCS 1502B:2025 хотын стандартад заасан технологийн дагуу гүйцэтгэнэ.
- 9.2. Сургуулийн барилгын дээвэр нь налуу хэлбэртэй байх бөгөөд ус хуримтлагдахгүйгээр урсах нөхцөлийг бүрдүүлсэн байна.
- 9.3. Дээврийн ба тусгаарлалтын суурь дээр зураг төслийн дагуу дараах ажлыг зайлшгүй хийх шаардлагатай. Үүнд:
  - угсармал хавтангуудын хоорондын заадсыг битүүлэх;
  - температур ашиглалтын заадас гаргах;
  - хавчуулга элементийг тогтоох;
  - тусгаарлалт ба цийдмэг шаваасан дээвэр буюу хуйлмал материал нийлж байгаа дээд талд чулуун бүтээцийн босоо гадаргуугийн дээд хэсгийг шавардах.
- 9.4. Сургуулийн барилгын дээвэр болон сургууль орчинд харилцаа холбооны антен, тоног төхөөрөмж байрлуулахыг хориглоно.
- 9.5. Ус зайлуулах суваг нь бат бөх, тэсвэртэй материалаар хийгдсэн байх бөгөөд Галвинисан ган, PVC, эсвэл зэвэрдэггүй ган суваг ашиглаж болно.
- 9.6. Хур тунадасны бохирдлоос ус зайлуулах хоолойг хамгаалахын тулд тор суулгасан байна.
- 9.7. Дээврийн хур тунадасны ус зайлуулах системд сифонон системийг ашиглах нь зохимжтой.



Зураг 8. Дээврийн хур тунадасны ус зайлуулах сифонон систем (жишээ зураг)

## 10. СУРГУУЛИЙН БАРИЛГЫН ӨНГӨНИЙ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

- 10.1. Сургуулийн барилгын гадна өнгийг орчин тойрны байгалийн өнгө төрх, барилгын загвар дизайн, хийцлэлд уялдуулж сонгоно.
- 10.2. Барилга, байгууламжийн гадна өнгийг орчин тойрны байгалийн өнгө төрх, барилгын загвар дизайн, хийцлэлд уялдуулж сонгоно.
- 10.3. Фасадын өнгийг үндсэн, туслах, чимэглэлийн гэж ангилна.
- 10.4. Барилга байгууламжийн гадна фасадын өнгөний жишээг хүснэгт 1-т үзүүлэв.

Хүснэгт 1. Барилгын гадна фасадын өнгө (жишээ)

| ӨНГӨНИЙ ЭЗЛЭХ ХУВЬ                                                                                                                                              | ӨНГӨНИЙ КОД |          |          |           |           |            |
|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------|----------|----------|-----------|-----------|------------|
| “Үндсэн өнгө”<br>Барилгын өнгө төрхийг ерөнхийд нь илтгэх бөгөөд бага гялтаан (хрома)-той өнгө ашиглана. Нийт талбайн 60%-ийг эзэлнэ.                           | 2.5y 8.5/2  | 10y 9/1  | 6y 9/1   | 5y 8/1    | 10y 8/0.5 | 5y 7.5/0.5 |
| “Туслах өнгө”<br>Барилгын үндсэн өнгөтэй уялдаж нийцсэн байх ба нийт талбайн 30%-ыг эзэлнэ.                                                                     | N6          | 2.5y 6/4 | N5.5     | 10y 6/2   | 10y 6/1   | 7.5y 5/2   |
| “Чимэглэлийн өнгө”<br>Үндсэн болон суурь өнгөтэй зохицсон байна. Барилгын загвар, тодотгосон хийц элементийг сонгох нь зохистой. Нийт талбайн 5-10%-ийг эзэлнэ. | 5r 5/2      | N4       | 7.5y 4/2 | 5pb 4/1.5 | 7.5b 4/2  | 2.5y 4/2   |

## 11. СУРГУУЛИЙН ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

- 11.1. Барилга байгууламжийн ашиглалтын явцад газар хөдлөлтөд тэсвэргүй нь тогтоогдсон барилгад бэхэлгээ, хүчитгэл хийнэ.
- 11.2. Сургуулийн барилга нь иргэдийн эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд аюул учруулахгүй, бат бэх тогтвортой, галын аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, хор хөнөөлийг хязгаарлах нөхцөлийг хангана.
- 11.3. Сургуулийн барилга нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд зорчих, хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангасан, тэдний хэрэгцээ шаардлагад нийцсэн, MNS 6055:2009 стандартын шаардлагыг хангана.
- 11.4. Сургуулийн гадна орчныг бүхэлд нь хянах боломжтой хяналтын камер нь Теле хяналтын системийн техникийн ерөнхий шаардлага, /MNS 6423:2019/ болон олон улсын “IP 67 стандарт”-д нийцсэн байна. Хяналтын камер нь дараах шаардлагыг хангана. Үүнд:
  - Харанхуй, үзэгдэх орчин хязгаарлагдсан үед бичлэг хийх чадвартай;
  - Хүний зүс царай, гадаад дүр төрх, содон шинж тэмдгийг татаж томруулах боломжтой байх;
  - 8 баллын газар хөдлөлт,  $\pm 40^{\circ}\text{C}$ -д тэсвэртэй.

## 12. ШАЛГАХ ХУУДАС

Ерөнхий боловсролын сургуулийн барилгын гадна засал нь шаардлага хангаж байгаа эсэхийг дараах шалгуур үзүүлэлт (хүснэгт 2)-ын дагуу хянан шалгана.


*Хүснэгт 2. Шалгуур үзүүлэлт*

| №  | Шалгуур үзүүлэлт                                                                                                                          | Тийм                     | Үгүй                     |
|----|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------|--------------------------|
| 1  | Барилгын гадна засалд эрүүл ахуйн шаардлага хангасан, гарал үүсэл болон тохирлын үнэлгээний гэрчилгээтэй барилгын материал ашигласан эсэх | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 2  | Барилгын дотор болон гадна заслын бүртгэл, хувийн хэрэг хөтөлдөг эсэх                                                                     | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 3  | Гадна фасад нь гэгээлэг өнгөтэй эсэх                                                                                                      | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 4  | Гадна фасад нь ашиглалтын явцад хэв гажилт үүсэхээргүй, удаан эдэлгээтэй эсэх                                                             | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 5  | Сургуулийн гадна фасад галд тэсвэртэй эсэх                                                                                                | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 6  | Дулаалгын материал нь галд тэсвэртэй, чийг ус үл нэвтрүүлдэг эсэх                                                                         | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 7  | Цонхны үндсэн бүрдэл эд ангид ашиглалтын найдвартай ажиллагааны туршилт хийж баталгаажуулсан чанарын гэрчилгээтэй эсэх                    | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 8  | Цонхонд 2–3 давхар шиллэгээтэй, Low-E буюу дулаан хадгалалттай шил ашигласан эсэх                                                         | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 9  | Дээврийн үндсэн хийц нь стандартын дагуу бат бөх, аюулгүй материалаар хийгдсэн эсэх                                                       | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 10 | Дээврийн налуу нь стандарт шаардлага хангаж байгаа эсэх                                                                                   | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 11 | Дээврийн гадаргуу нь гадна ба дотор ус зайлуулагчаар хур борооны усыг бүрэн зайлуулах боломжтой эсэх                                      | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 12 | Ус зайлуулах суваг нь бат бөх, зэврэлтэд тэсвэртэй материалаар хийгдсэн эсэх                                                              | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 13 | Ус зайлуулах системд аюулгүй ажиллагааны хаалт, тор хамгаалалт суурилуулсан эсэх                                                          | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 14 | Дээвэрт ус нэвчилт илрээгүй эсэх                                                                                                          | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 15 | Аянга зайлуулагч систем бүрэн ажиллагаатай эсэх                                                                                           | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |

**Тайлбар:** Ерөнхий боловсролын сургуулийн байгууллагын барилгын гадна засал нь дээрх бүх шаардлагыг хангаж байх ёстой бөгөөд шаардлага хангасан бол **“Тийм”** хийгдээгүй буюу хийгдсэн боловч шаардлага хангахгүй байгаа бол **“Үгүй”** хэсгийг тэмдэглэнэ.

## ХАВСРАЛТ – А.1


Ерөнхий боловсролын сургуулийн барилгын фасадын зураглал. /Жишээ/




ХАВСРАЛТ – А.2

Ерөнхий боловсролын сургуулийн барилгын фасадын зураглал. /Жишээ/

ХАЖУУ ТАЛ /Зүүн/




ХАЖУУ ТАЛ /Баруун/



## ХАВСРАЛТ – В.1

Ерөнхий боловсролын сургуулийн барилгын харагдах байдал. /Жишээ/  
Металл фасадтай



## ХАВСРАЛТ – В.2

Ерөнхий боловсролын сургуулийн барилгын харагдах байдал. /Жишээ/  
Чулуун будгаар хийсэн фасадтай



### ХАВСРАЛТ – В.3

Ерөнхий боловсролын сургуулийн барилгын харагдах байдал. /Жишээ/  
Чулуун фасадтай



## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Боловсролын ерөнхий хууль;
- Хот байгуулалтын тухай;
- Газрын тухай хууль;
- Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль;
- БНБД 30-01-04 Хот, тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм;
- БНБД 21-04-05 Барилга байгууламжийн гал унтраах автомат төхөөрөмж, дохиоллын хэрэгсэл;
- БНБД 31-03-03 Олон нийт иргэний барилга;
- БНБД 23-02-08 “Байгалийн ба зохиомол гэрэлтүүлэг”;
- MNS 6423:2019 “Теле хяналтын системийн техникийн ерөнхий шаардлага”;
- “The Building Quality Standards Handbook” by Victorian School Building Authority. 2019;
- Alaska School Design & Construction Standards. 2022;
- Building Construction Illustrated by Francis D.K. Ching;
- Architectural Graphic Standards by The American Institute of Architects (AIA).







Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг  
ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗАР



Хан-Уул дүүрэг, 23 дугаар хороо, Наадамчдын зам 1201,  
Нийслэлийн нутгийн захиргааны цогцолбор Б байр



72707700



[www.uds.ub.gov.mn](http://www.uds.ub.gov.mn)



Хот байгуулалт, хотын стандартын газар